

Суралцах үйл ажиллагаа 1:

Тунгаан бодох ба хувийн илчлэлт

Амьдралдаа илчлэлт хүлээн авах талаар та юу сурсан бэ? Хиламан 10-ын эхний хэсэгт бид Нифай Бурханаас хүч, илчлэлт хүлээн авсан туршлагын талаар сурсан. Нифайн жишээ нь бид Их Эзэнээс илчлэлт хүлээн авах, таних чадвараа хэрхэн нэмэгдүүлж болохыг заадаг.

Хиламан 10:1-3-ыг уншаад, Нифайг юу Их Эзэнээс илчлэлт хүлээн авахад хүргэснийг олж мэд.

2, 3-р шүлэг-ээс *тунгаан бодох* гэсэн үгийг тэмдэглэ. Та энэ үгийг судар дээрээ тэмдэглэхийг хүсэж болно.

Бидний эдгээр шүлгээс сурч болох нэг үнэн бол Их Эзэний зүйлсийг тунгаан бодох нь биднийг илчлэлт хүлээн авахад бэлтгэдэг юм.

- Та энэ нь юу болох талаар эргэлзэж байгаа хүнд тунгаан бодохыг хэрхэн тайлбарлаж болох вэ?
- Тунгаан бодох нь бидэнд илчлэлт хүлээн авахад яагаад тусалж болох вэ

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч М.Рассэлл Баллард ийн заасан:



Нам гүм байдалд байж, Сүнсийг сонсож мөн дагах нь чухал. Дэлхийн түүхийн аль ч цаг үеийн хүмүүсийн амьдралд байгаагүй бидний анхаарлыг сарниулах зүйлс амьдралд маань хэтэрхий олон байна.

Хүн бүрд бясалгах мөн эргэцүүлэн бодох цаг хэрэгтэй. Дэлхийн Аврагч хүртэл мөнх бус тохинууллынхаа үеэр үүнийг хийх цаг гаргасан байна. (М.Рассэлл Баллард, “Тэмцэлдэхээ больж, намайг Бурхан гэдгийг мэд” 2014 оны 5-р сарын 4-ний

Залуучуудад зориулсан СБС-ийн онцгой цугларалт], broadcasts.ChurchofJesusChrist.org)

- Сүнслэг зүйлсийн талаар тунгаан бодоход хэцүү болгодог зарим анхаарал сарниулах зүйл юу вэ?
- Таны хувьд тунгаан бодох шаардлагатай “Их Эзэний зүйлс” юу вэ?
- Тунгаан бодох нь илчлэлт хүлээн авахад хүргэсэн ямар туршлага танд байдаг вэ? Мөн ийм ямар туршлагыг та мэдэх вэ?

Энэ үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэхэд туслах зорилгоо бод. Зорилгоо судлах тэмдэглэлдээ бичиж тэмдэглэ.